



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/277

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 44 дүгээр тушаалын 10 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор “Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын гадна ачаа, шуудан буулгах, ачих талбайн зураг төсөл боловсруулах, барилгын ажил”-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Н.Мягмарсүрэн	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны дэд дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Алдар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	П.Дорж	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны Барилга байгууламжийн засвар арчлалтын хэсгийн дарга
	Б.Энх-Амгалан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Х.Болор-Эрдэнэ	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Н.Мягмарсүрэн/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Бат-Алдар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН